



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 29/16

Арвайхээр сум

Г Аймгийн аялал жуулчлалын бүс Г
тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.13 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн байгаль, түүх соёлын өв, дурсгалт газрыг түшиглэн аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор орон нутгийн аялал жуулчлалын бүсийг Орхоны хөндийн, Өндөр Гэгээн Занабазарын түүхэн замналын, Соёлын болон тусгай сонирхлын, Говийн гэсэн дөрвөн аялал жуулчлалын бүстэй байхаар тогтоосугай.

2.Аялал жуулчлалын бүсийн хилийн зааг болон менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

